



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: АРА-2022/26/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Архангай аймаг  
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх  
аудитор: Т.Байгалмаа  
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар  
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Алтанчимэг  
Утас: 90060105 Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

1.Аудитын тайлан.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Төлбөрийн акт.....	15
4.2 Албан шаардлага .....	15
4.3 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## 1.Аудитын тайлан



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс:976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 7  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН  
ГАЗРЫН ДАРГА П.ГОМБОДОРЖ  
ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

##### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

##### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

##### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

##### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>377,641,378.25</b>	<b>360,192,964.25</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>377,641,378.25</b>	<b>352,992,964.25</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>242.00</b>	<b>118.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	242.00	118.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>364,801,136.25</b>	<b>338,572,846.25</b>
35410	Бичиг хэргийн материал	1,124,791.00	1,890,091.00
35470	Бусад хангамжийн материал	363,676,345.25	336,682,755.25
35600	Мал амьтад	12,840,000.00	14,420,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>472,101,866.68</b>	<b>488,660,263.92</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>472,101,866.68</b>	<b>488,660,263.92</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>436,145,200.04</b>	<b>453,690,263.88</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	406,708,210.00	406,708,210.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,691,635.36	-25,477,668.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	122,292,087.15	122,292,087.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	-91,219,946.75	-113,646,253.85
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	50,575,501.48	104,978,306.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37,846,306.05	-43,557,309.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,898,603.83	18,198,603.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16,710,854.11	-16,845,437.45
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,096,088.00	2,096,088.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-956,548.15	-1,056,361.87
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>35,956,666.64</b>	<b>34,970,000.04</b>
39301	Програм хангамж	6,800,000.00	6,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,033,333.36	-5,019,999.96
39303	Бусад биет бус хөрөнгө	33,190,000.00	33,190,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>849,743,244.93</b>	<b>848,853,228.17</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,740,000.00</b>	<b>0.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,740,000.00</b>	<b>0.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>2,740,000.00</b>	<b>0.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,750,000.00	0.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>990,000.00</b>	<b>0.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	990,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>847,003,244.93</b>	<b>848,853,228.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>847,003,244.93</b>	<b>848,853,228.17</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,580,093,081.39	1,580,093,081.39
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-852,966,701.43</b>	<b>-851,116,718.19</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-954,373,376.38	-852,966,701.43
51220	Тайлант үеийн үр дүн	101,406,674.95	1,849,983.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	119,876,864.97	119,876,864.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>849,743,244.93</b>	<b>848,853,228.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,017,917,567.84</b>	<b>685,213,818.96</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>528,271,221.65</b>	<b>228,463,447.96</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>528,271,221.65</b>	<b>228,463,447.96</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>2,070,000.00</b>	<b>3,380,000.00</b>
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,070,000.00	3,380,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	116,412,957.00	69,582,804.96
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	409,788,264.65	155,500,643.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>489,646,346.19</b>	<b>456,750,371.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>460,587,900.00</b>	<b>420,560,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	460,587,900.00	420,560,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>29,058,446.19</b>	<b>36,189,971.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,993,684.00	16,101,971.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	20,088,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>916,510,892.89</b>	<b>683,363,835.72</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>916,510,892.89</b>	<b>668,183,835.72</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>903,469,411.73</b>	<b>623,593,591.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>197,577,600.00</b>	<b>215,582,988.29</b>
210101	Үндсэн цалин	157,953,100.00	172,749,336.22
210102	Нэмэгдэл	31,824,200.00	35,603,652.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,800,300.00	7,230,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,375,800.00</b>	<b>28,330,717.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,560,800.00	19,840,676.39
210202	Тэтгэмжийн даатгал	1,953,800.00	2,204,770.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,563,000.00	1,727,089.36
210204	Ажилгүйдлийн даатгал	390,700.00	414,380.23
210205	Эрүүл мэндийн даатгал	3,907,500.00	4,143,800.39
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,391,014.55</b>	<b>33,803,904.73</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,379,265.98	981,108.13
210302	Түлш, халаалт	24,390,640.00	32,161,113.00
210303	Цэвэр, бохир ус	621,108.57	661,683.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>36,622,476.00</b>	<b>33,143,168.00</b>
210401	Бичиг хэрэг	7,645,112.00	3,499,643.00
210402	Тээвэр, шатахуун	26,600,566.00	26,118,431.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,769,275.00	1,627,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,800.00	44,200.00
210408	Бараа материал акталсны зардал	533,723.00	1,853,124.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,959,900.00</b>	<b>7,196,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,959,900.00	7,196,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>172,843,429.48</b>	<b>76,990,745.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,878,048.48	72,180,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	682,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,000.00	197,064.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	671,500.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	12,881.00	12,881.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>423,290,191.70</b>	<b>228,545,667.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	375,116,331.63	189,401,260.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,173,860.07	39,144,407.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,041,481.16</b>	<b>44,590,244.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,900,000.00</b>	<b>33,988,474.17</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	29,616,574.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,900,000.00	4,371,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,141,481.16</b>	<b>10,601,770.49</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,065,980.97	10,601,770.49
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>15,180,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>15,180,000.00</b>
221001	Их засвар	0.00	15,180,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>101,406,674.95</b>	<b>1,849,983.24</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>101,406,674.95</b>	<b>1,849,983.24</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	120,125,282.09	-954,621,793.50	745,596,569.98
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	248,417.12	248,417.12
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,580,093,081.39	120,125,282.09	-954,373,376.38	745,844,987.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-248,417.12	0.00	-248,417.12
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	101,406,674.95	101,406,674.95
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	119,876,864.97	-852,966,701.43	847,003,244.93
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,580,093,081.39	119,876,864.97	-852,966,701.43	847,003,244.93
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,580,093,081.39	119,876,864.97	-852,966,701.43	847,003,244.93
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,849,983.24	1,849,983.24
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,580,093,081.39	119,876,864.97	-851,116,718.19	848,853,228.17

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>492,213,034.19</b>	<b>456,750,371.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>492,213,034.19</b>	<b>456,750,371.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>460,587,900.00</b>	<b>420,560,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	460,587,900.00	420,560,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>31,625,134.19</b>	<b>36,189,971.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,993,684.00	16,101,971.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,566,688.00	20,088,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>490,063,034.19</b>	<b>455,450,371.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>490,063,034.19</b>	<b>455,450,371.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>477,021,553.03</b>	<b>410,540,026.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>197,577,600.00</b>	<b>215,582,988.36</b>
210101	Үндсэн цалин	157,953,100.00	172,856,098.29
210102	Нэмэгдэл	31,824,200.00	35,556,890.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,800,300.00	7,170,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,375,800.00</b>	<b>28,330,717.25</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,560,800.00	19,840,676.26
210202	Тэтгэмжийн даатгал	1,953,800.00	2,204,771.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,563,000.00	1,727,089.35
210204	Ажилгүйдлийн даатгал	390,700.00	414,380.23
210205	Эрүүл мэндийн даатгал	3,907,500.00	4,143,800.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>26,391,014.55</b>	<b>33,803,904.73</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,379,265.98	981,108.13
210302	Түлш, халаалт	24,390,640.00	32,161,113.00
210303	Цэвэр, бохир ус	621,108.57	661,683.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,936,919.00</b>	<b>24,955,021.00</b>
210401	Бичиг хэрэг	2,180,062.00	1,914,120.00
210402	Тээвэр, шатахуун	16,507,192.00	20,571,301.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,775,275.00	2,187,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,800.00	44,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400,590.00	237,630.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,435,260.00</b>	<b>495,000.00</b>
210604	Урсгал засвар	2,435,260.00	495,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>17,447,400.00</b>	<b>7,442,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	17,447,400.00	7,442,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>181,055,559.48</b>	<b>93,668,445.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	179,090,178.48	81,658,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	682,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,000.00	197,064.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	671,500.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	12,881.00	12,881.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,932,000.00</b>	<b>6,261,650.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,932,000.00	6,261,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,041,481.16</b>	<b>44,910,344.66</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>9,900,000.00</b>	<b>34,308,574.17</b>

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	29,616,574.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,900,000.00	4,692,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,141,481.16</b>	<b>10,601,770.49</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,065,980.97	10,601,770.49
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,150,000.00</b>	<b>1,300,000.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>2,150,000.00</b>	<b>1,300,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,150,000.00</b>	<b>1,300,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,150,000.00</b>	<b>1,300,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,150,000.00	1,300,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,150,000.00</b>	<b>-1,300,000.00</b>
<b>7</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>0</u>	<u>0</u>
<b>8</b>	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>0</u>	<u>0</u>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>420,560,400.00</b>	<b>409,958,629.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>420,560,400.00</b>	<b>409,958,629.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>386,161,200.00</b>	<b>375,650,055.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>224,104,000.00</b>	<b>215,582,988.36</b>
210101	Үндсэн цалин	178,382,400.00	172,856,098.29
210102	Нэмэгдэл	37,921,300.00	35,556,890.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,800,300.00	7,170,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,254,200.00</b>	<b>28,330,717.25</b>
210201	Тэтгэврийн даатгал	21,289,900.00	19,840,676.26
210202	Тэтгэмжийн даатгал	2,241,100.00	2,204,771.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,792,800.00	1,727,089.35
210204	Ажилгүйдлийн даатгал	448,300.00	414,380.23
210205	Эрүүл мэндийн даатгал	4,482,100.00	4,143,800.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>33,810,000.00</b>	<b>33,803,904.73</b>
210301	Гэрэл, цахилгаан	977,800.00	981,108.13
210302	Түлш, халаалт	32,161,100.00	32,161,113.00
210303	Цэвэр, бохир ус	671,100.00	661,683.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,339,000.00</b>	<b>7,339,000.00</b>
210401	Бичиг хэрэг	2,041,100.00	1,651,200.00
210402	Тээвэр, шатахуун	3,376,200.00	3,778,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,627,300.00	1,627,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	44,200.00	44,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	250,200.00	237,630.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>495,000.00</b>	<b>495,000.00</b>
210604	Урсгал засвар	495,000.00	495,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>2,231,300.00</b>	<b>2,231,300.00</b>

210702	Дотоод албан томилолт	2,231,300.00	2,231,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>83,640,000.00</b>	<b>83,579,445.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,630,000.00	71,569,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,100.00	197,064.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	12,900.00	12,881.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,287,700.00</b>	<b>4,287,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,287,700.00	4,287,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,399,200.00</b>	<b>34,308,574.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,399,200.00</b>	<b>34,308,574.17</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,707,200.00	29,616,574.17
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,692,000.00	4,692,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>420,560,400.00</b>	<b>409,958,629.51</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>420,560,400.00</b>	<b>409,958,629.51</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	420,560,400.00	409,958,629.51
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>45.00</b>	<b>43.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>22.00</b>	<b>21.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	10.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>22.00</b>	<b>21.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17.00	11.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	10.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>36189971.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>36189971.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	36189971.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17616021.00
210401	Бичиг хэрэг	262,920.00
210402	Тээвэр, шатахуун	16,793,101.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	560,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5211000.00
210702	Дотоод албан томилолт	5,211,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10089000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,089,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3273950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,273,950.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	36,189,971.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	36,189,971.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	16,101,971.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,088,000.00
--------	--	---------------

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн, бараа материалын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 3 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж, эрүүл хүнс, органик бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, шинэ санаа дэвшилтэд технологийг нэвтрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ХХААХҮЯ-ны харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжийн хүрээнд 2021 оны 6 дугаар сарын 11-ны “Нийгмийн даатгалын тухай сангийн тухай хууль”-д нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн ХХААГ-ын Хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах, Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтад төсвийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллах 1 заалт бүхий арга хэмжээг тусгаж улирал бүр үйл ажиллагаандаа тайлагнаж ажилласан тул дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 420.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 2.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу бэлтгэн, төсвийн гүйцэтгэлийн тайланг хөтөлбөр арга хэмжээгээр тайлагнан, тайлбар танилцуулгын хамт ирүүлсэн байна.

2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 0.9 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна. Эхний үлдэгдлийн үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материал, урьдчилж гарсан зардлын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Урьдчилж гарсан зардал		7.2	7.2	100.0
Бараа материал	377.6	352.9	-24.7	-7.0
Үндсэн хөрөнгө	472.1	488.7	16.6	3.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>849.7</b>	<b>848.8</b>	-0.9	-0.1
<b>Өр төлбөр</b>	2.7	0.00	-2.7	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	847.0	848.8	1.8	0.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>849.7</b>	<b>848.8</b>	-0.9	-0.1

3.5.1 Бараа материалын эцсийн үлдэгдэл 24.7 сая төгрөг буюу 7 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 377.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 33.8 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй АРА-2022/26/НА-СТА-ТШЗ

хүлээн авсан 158.8 сая төгрөг нийт 192.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 217.3 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 352.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 3.4 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 472.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.3 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 54.4 сая төгрөг нийт 55.7 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 39.1 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч 488.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Урьдчилж гарсан дансны эцсийн үлдэгдэл 7.2 сая төгрөг байгаа нь 2022 оны программ ашигласны төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5.4 Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл тайлант хугацаанд 1.8 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 417.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 3.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг 420.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан 420.5 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авч 409.9 сая төгрөгийг зарцуулж 10.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 10.5 сая төгрөг, урсгал шилжүүлгээс 0.09 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн газраас малчдад тусламж хүргүүлэх, өвөлжилт хаваржилтын байдалд хяналт тавих заавар зөвлөмж хүргүүлэхэд 20.1 сая төгрөг, Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс 14.1 сая төгрөг, Аймгийн ОНХС-аас 2.1 сая төгрөг төгрөг нийт 36.2 сая төгрөгийн санхүүжилт ирснийг холбогдох журамд нийцүүлэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. ХХААХҮЯ-аас өгсөн чиглэлийн дагуу 2021 оны 12 сард 7.2 сая төгрөгийг “ДАТА ЛАНД” ХХК-д программын үйлчилгээний дараа жилийн төлбөрийг шилжүүлж санхүүгийн тайланд урьдчилж төлсөн зардлаар тайлагнасан байна. Энэ нь ХХААХҮЯ-ны харьяа бүх байгууллагуудад гарсан байх магадлалтай тул аудитын Хоёрдугаар газарт уг асуудлыг Төсвийн Ерөнхийлөн захирагчийн хэмжээнд нэгдсэн байдлаар шалгах саналыг хүргүүллээ.
2. ХХААХҮЯ-ны сайдын 2021 оны А/225 тоот тушаалаар батлагдсан Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 15.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ХХААГ-ын конторын барилгын дотор засварын ажлыг Бибор ХХК-иар гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, ажлыг 2021 оны 11 сарын 03-ны өдөр хүлээн авсан байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь 2021 оны 9-р сар батлагдсан нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 3.4 дэх заалттай нийцэхгүй байна. Иймд уг асуудлыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгдсэн тайланд тусгуулахаар саналыг хүргүүлэв.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 420.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 409.9 сая төгрөгийг зарцуулж, 97.4 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
  - Албан конторын тавилга худалдан авахад 1.3 сая төгрөг зарцуулсан байна.
  - Тайлант жилд урсгал зардлаас 10.6 сая төгрөгийн хэмнэлт гаргаж улсын төсөвт төвлөрүүлсэн нь батлагдсан төсвийн 2.5 хувийг эзэлж байна.
  - Албан томилолт, бичиг хэргийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
2. Төрийн бус байгууллагуудаас авсан ажил үйлчилгээний төлбөрт олгосон санхүүжилтийн хувьд: Монгол мал хөтөлбөрийн малын чанар сайжруулах цөм сүрэг бүрдүүлэх, үзлэг ангиллын ажлын хүрээнд 5 төрийн бус байгууллагад 17.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
3. Суудлын автомашин ашиглалтын хувьд: 2014, 2017 онд үйлдвэрлэгдсэн 119.7 сая төгрөгийн өртөгтэй Ланд-200, УАЗ-фургон 2 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 13.8 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой цалингийн зардалд 12.6 сая төгрөгийг олгосон байна.
4. Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан ажил үйлчилгээний гэрээний хувьд: 3 хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулж өвөлжилт, хадлан тариалалт зэрэг цаг үеийн асуудлын талаар мэдээ, мэдээллийг бэлтгэхэд 3.0 сая төгрөгийн зардал гарсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад зөрчил илрээгүй.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн Хүнс хөдөө аж ахуй газар нь тайлант хугацаанд оруулбал зохих 88 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд батлагдсан төсвийн 10.1 хувь буюу 10.6 сая төгрөгийн хэмнэлт бий болгож төсөвт буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэж байна.

“Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 43 дугаар тогтоолтой нийцүүлэн үзэхэд Хүнс хөдөө аж ахуйн газар нь 1.3 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэж тус тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон Өглөгийн тооцоо барагдуулахтай холбоотой 2 албан шаардлага, дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр 1 зөвлөмжийг хүргүүлж биелэлтийг ХХААГ-ын даргын 2021.05.31-ны 1/237 тоот албан бичгээр хангуулсан бөгөөд тайлант хугацаанд зөвлөмжийн хэрэгжилтийг хянан үзэхэд алдаа зөрчлийг давтан гаргаагүй байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Аудитаас хүргүүлж байгаа шийдвэрийн хэрэгжилтийг давтан шалгах

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 173.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 157.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг тус тус хүргүүлээ.

##### 4.1 Төлбөрийн акт

Мал аж ахуйн албаны мэргэжилтэн Ч.Чулуунбаяр нь шүүхээр ажилгүй байсан хугацааны НДШ-ээ төлүүлэх, ажилдаа эргэн томилуулах шийдвэр гаргуулан 2021 оны 10 сарын 20-ны 109/ШШ2021/0040 захирамжаар ажилдаа эргэн томилогдсон байхад өмнө олгосон 14.7 сая төгрөгийн тэтгэмжийг буцаан төвлөрүүлээгүй байсныг аудитын явцад төлбөрийн акт тогтоож, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж ажиллалаа.

##### 4.2 Албан шаардлага

Төсвийн хөрөнгөөр 1.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авахдаа төсөвт зохицуулалт хийгээгүй бараа үйлчилгээний зардлаас бэлтгэсэн нь Сангийн сайдын 2018 оны 134-р тушаал, Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

##### 4.3 Зөвлөмж

Аудитаас дараах зөвлөмжийг хүргүүлээ. Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 4.3.1 Бараа материалын данстай холбоотой асуудал

- Шатахууны зарцуулалтыг анхан шатны баримтаар тулган шалгахад жолоочийн тооцооны хуудас болон автомашины спидометрийн заалтыг бичиж хэвшсэн хэдий ч шатахууны нормыг тооцохдоо Зам, тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөөгүй байна. Иймд Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаал "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж хэвших

###### 4.3.2 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс тулгахад ХХААГ-ын балансад 156 нэр төрлийн 142,651.8 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээ бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан байна. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу элэгдлээ нөхсөн хөрөнгөд арга хэмжээ авч ажиллах

###### 4.3.3 Бараа материалын данстай холбоотой асуудал

- ХХААГ санхүүгийн тайланд нийт 14,420.0 мянган төгрөгийн 115 тооны мал амьтад бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд 1,800.0 мянган төгрөгийн 13 тоо толгой мал өвчний улмаас хорогдсоныг эмчийн актыг үндэслэж данснаас хассан бол 3,380.0 мянган төгрөгийн 20 тоо толгой малын нас дэвшилтийг бүртгэлд тусгасан байна. Тус байгууллагын мал амьтадын хувьд малыг захиран зарцуулах тусгайлсан эрхийн актгүй, малын ашиг шимийг хүртэх тооцоо судалгаагүй, төл бүртгэх бүртгэлгүй, анхан шатны баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна. Иймд Мал амьтдыг бүрэн бүртгэлжүүлж, ашиг шимийг хүртэх тодорхой арга хэмжээ авч, анхан шатны нотлох баримтыг бүрдүүлэн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

*/сая төгрөгөөр/*

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХХААГ	5	173.1			1	14.7	1	1.3	3	157.1